**ИХЭРМӨРӨН АУДИТ ХХК**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2023/174/НА-СТА-ТШЗ


Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум 2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: С.Гансүх

Утас:95908400 Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ....4
Асуудлыг онцолсон хэсэг....4
Аудитын гол асуудал....4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ....5
4. АУДИТЫН ТАЙЛАН....18
4.1 Ерөнхий зүйл....18
4.2 Материаллаг байдал....19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт....19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....20
4.5.1 Завсрын аудитын талаар....20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал....20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....20
5.1 Зөвлөмж....21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БШУС | Боловсрол, шинжлэх ухааны сайд |
| БСШУС | Боловсрол, соёл,шинжлэх ухааны сайд |
| БШУГ | Боловсрол, шинжлэх ухааны газар |
| УИХ | Улсын их хурал |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/124

танай ______________ -ны № ______________ -т

ТҮНЭЛ СУМЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.НЯМДЭЛГЭР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам”-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгө данс 72,210.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

**Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөг суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудыг аудитын гол асуудал гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Сургуулийн захирал Түнэл сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 77 арга хэмжээг төлөвлөж, 92.1 хувьтай дүгнэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх

үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А. ЭРДЭНЭБААТАР

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **157,879,265.27** | **261,844,009.27** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | **72,210,901.00** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | **72,210,901.00** |
| **31210** | **Төгрөг** | - | **72,210,901.00** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 72,210,901.00 |
| **33** | **АВЛАГА** | - | **9,872,000.00** |
| **33500** | **Бусад авлага** | - | **9,872,000.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | - | 9,872,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **157,879,265.27** | **179,761,108.27** |
| **35100** | **Түүхий эд материал** | **3,294,969.00** | **3,294,969.00** |
| 35130 | Эм боох материал | 3,294,969.00 | 3,294,969.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | - | 1,918,953.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **154,584,296.27** | **174,547,186.27** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 685,054.00 | 3,048,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 131,368,942.23 | 135,515,641.23 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,360,000.04 | 840,000.04 |
| 35450 | Барилгын засварын материал | 13,314,250.00 | 2,782,150.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,776,450.00 | 30,359,135.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,079,600.00 | 2,002,260.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,560,442,458.80** | **2,505,489,176.02** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,560,442,458.80** | **2,505,489,176.02** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **2,523,809,025.51** | **2,468,905,742.77** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,569,577,833.00 | 2,569,577,833.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (206,964,481.62) | (300,702,237.58) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 226,338,780.24 | 274,783,727.24 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (148,153,497.54) | (168,866,061.11) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 128,235,422.66 | 148,692,559.43 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (74,522,600.56) | (87,382,267.54) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 25,409,775.66 | 25,409,775.66 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (25,409,775.66) | (25,409,775.66) |
| 39217 | Ном | 29,297,569.33 | 32,802,189.33 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **36,633,433.29** | **36,583,433.25** |
| 39301 | Програм хангамж | 1,604,000.00 | 1,604,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,408,166.71) | (1,458,166.75) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 36,437,600.00 | 36,437,600.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,718,321,724.07** | **2,767,333,185.29** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,718,321,724.07** | **2,767,333,185.29** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,718,321,724.07** | **2,767,333,185.29** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 759,822,360.46 | 759,822,360.46 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 759,822,360.46 | 759,822,360.46 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **1,525,432,879.37** | **1,574,444,340.59** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (261,502,367.51) | 1,522,742,879.37 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,786,935,246.88 | 51,701,461.22 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 433,066,484.24 | 433,066,484.24 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,718,321,724.07** | **2,767,333,185.29** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **3,083,413,715.18** | **1,602,927,455.77** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,839,870,022.63** | **52,131,955.77** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,839,870,022.63** | **36,310,956.77** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **-** | **2,347,300.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 2,347,300.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 1,839,690,122.63 | 33,963,656.77 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 179,900.00 | - |
| **122** | **Тусламжийн орлого** | **-** | **15,820,999.00** |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | - | 15,820,999.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,243,543,692.55** | **1,550,795,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,003,469,900.00** | **1,277,651,200.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 1,277,651,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,003,469,900.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **12,848,592.55** | **-** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,288,592.55 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 560,000.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **227,225,200.00** | **273,144,300.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 227,225,200.00 | 273,144,300.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,296,478,468.30** | **1,551,225,994.55** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,296,478,468.30** | **1,551,225,994.55** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,245,836,838.75** | **1,489,273,578.55** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **768,709,235.00** | **905,097,291.00** |
| 210101 | Үндсэн цалин | 622,213,798.00 | 717,403,355.00 |
| 210102 | Нэмэгдэл | 98,685,341.00 | 164,451,299.00 |
| 210104 | Урамшуулал | 47,810,096.00 | 23,242,637.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **99,674,758.00** | **112,029,955.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 69,044,110.13 | 76,338,949.46 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,703,469.59 | 8,981,046.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,162,775.71 | 7,184,837.31 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,524,036.57 | 1,794,900.85 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,240,366.00 | 17,730,220.71 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **204,005,458.00** | **207,947,372.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,821,304.00 | 8,997,548.00 |
| 210302 | Түлш, халаалт | 194,585,714.00 | 197,449,824.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 598,440.00 | 1,500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **18,276,489.93** | **16,699,404.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 423,000.00 | 6,284,154.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,629,500.00 | 5,559,460.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 12,246,569.93 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,977,420.00 | 4,855,790.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **43,397,049.00** | **74,814,670.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 839,850.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 42,557,199.00 | 74,814,670.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,051,687.95** | **17,858,100.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 40,657.95 | - |
| 210604 | Урсгал засвар | 5,011,030.00 | 17,858,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **210,000.00** | **-** |
| 210702 | Дотоод албан томилолт | 210,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,187,000.00** | **7,062,300.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,587,000.00 | 2,312,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 4,750,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **103,325,160.87** | **147,764,486.55** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 16,284,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,548,500.00 | 4,120,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 96,776,660.87 | 127,359,986.55 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **50,641,629.55** | **61,952,416.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **30,921,300.00** | **56,418,624.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 30,921,300.00 | 56,418,624.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **7,187,842.00** | **5,533,792.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,187,842.00 | 5,533,792.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **12,532,487.55** | **-** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,532,487.55 | - |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | **1,786,935,246.88** | **51,701,461.22** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | **1,786,935,246.88** | **51,701,461.22** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **1,243,543,692.55** | **1,553,142,800.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **2,347,300.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **-** | **2,347,300.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **-** | **2,347,300.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 2,347,300.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,243,543,692.55** | **1,550,795,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,003,469,900.00** | **1,277,651,200.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 1,277,651,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,003,469,900.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **12,848,592.55** | **-** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,288,592.55 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 560,000.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **227,225,200.00** | **273,144,300.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 227,225,200.00 | 273,144,300.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,212,795,242.55** | **1,453,062,899.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,212,795,242.55** | **1,453,062,899.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,180,053,471.00** | **1,376,878,783.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **768,709,235.00** | **905,097,291.00** |
| 210101 | Үндсэн цалин | 548,433,421.00 | 728,679,175.00 |
| 210102 | Нэмэгдэл | 174,476,214.00 | 159,820,692.00 |
| 210104 | Урамшуулал | 45,799,600.00 | 16,597,424.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **99,674,758.00** | **112,029,955.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 88,454,714.63 | 91,934,692.24 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,402,351.25 | 5,023,813.86 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 488,556.22 | 4,019,051.12 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 120,830.52 | 1,004,762.74 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,208,305.38 | 10,047,635.04 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **204,005,458.00** | **207,947,372.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,821,304.00 | 8,997,548.00 |
| 210302 | Түлш, халаалт | 194,585,714.00 | 197,449,824.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 598,440.00 | 1,500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **8,967,800.00** | **-** |
| 210401 | Бичиг хэрэг | 522,800.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,300,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 456,600.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,688,400.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **48,066,020.00** | **84,165,655.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 212,250.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 46,318,170.00 | 84,165,655.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,535,600.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **43,558,900.00** | **10,000,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 17,357,000.00 | - |
| 210602 | Тавилга | 10,170,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 16,031,900.00 | 10,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **210,000.00** | **-** |
| 210702 | Дотоод албан томилолт | 210,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,669,000.00** | **11,052,300.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,069,000.00 | 2,312,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 8,740,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,192,300.00** | **46,586,210.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 33,925,960.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,192,300.00 | 12,660,250.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **32,741,771.55** | **76,184,116.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **13,021,442.00** | **70,650,324.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 13,021,442.00 | 70,650,324.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **7,187,842.00** | **5,533,792.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,187,842.00 | 5,533,792.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **12,532,487.55** | **-** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,532,487.55 | - |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **30,748,450.00** | **100,079,901.00** |
| **IV** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **-** | **-** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **30,748,450.00** | **27,869,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **30,748,450.00** | **27,869,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **30,748,450.00** | **27,869,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 30,748,450.00 | 27,869,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(30,748,450.00)** | **(27,869,000.00)** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **-** | **-** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **72,210,901.00** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 72,210,901.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 759,822,360.46 | 437,959,134.06 | (263,844,622.33) | 933,936,872.19 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 2,342,254.82 | 2,342,254.82 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 759,822,360.46 | 437,959,134.06 | (261,502,367.51) | 936,279,127.01 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | (4,892,649.82) | - | (4,892,649.82) |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 1,786,935,246.88 | 1,786,935,246.88 |
| 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 759,822,360.46 | 433,066,484.24 | 1,525,432,879.37 | 2,718,321,724.07 |
| 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 759,822,360.46 | 433,066,484.24 | 1,525,432,879.37 | 2,718,321,724.07 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | (2,690,000.00) | (2,690,000.00) |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 759,822,360.46 | 433,066,484.24 | 1,522,742,879.37 | 2,715,631,724.07 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 51,701,461.22 | 51,701,461.22 |
| 2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 759,822,360.46 | 433,066,484.24 | 1,574,444,340.59 | 2,767,333,185.29 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

## Улсын төсвийн гүйцэтгэл

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,279,963,500.00** | **1,207,787,599.00** | **72,175,901.00** | **94.36** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,279,963,500.00** | **1,207,787,599.00** | **72,175,901.00** | **94.36** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,204,891,300.00** | **1,137,137,275.00** | **67,754,025.00** | **94.38** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **914,971,400.00** | **870,742,126.12** | **44,229,273.88** | **95.17** |
| 210101 | Үндсэн цалин | 694,479,800.00 | 657,010,901.12 | 37,468,898.88 | 94.60 |
| 210102 | Нэмэгдэл | 196,852,900.00 | 190,499,941.00 | 6,352,959.00 | 96.77 |
| 210104 | Урамшуулал | 23,638,700.00 | 23,231,284.00 | 407,416.00 | 98.28 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **114,371,400.00** | **96,721,983.88** | **17,649,416.12** | **84.57** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 77,772,600.00 | 76,626,721.12 | 1,145,878.88 | 98.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,149,700.00 | 5,023,813.86 | 4,125,886.14 | 54.91 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,319,700.00 | 4,019,051.12 | 3,300,648.88 | 54.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,830,000.00 | 1,004,762.74 | 825,237.26 | 54.91 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,299,400.00 | 10,047,635.04 | 8,251,764.96 | 54.91 |
| **2105** | **Нормативт зардал** | **84,213,600.00** | **84,165,655.00** | **47,945.00** | **99.94** |
| 210502 | Хоол, хүнс | 84,213,600.00 | 84,165,655.00 | 47,945.00 | 99.94 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **11,088,000.00** | **11,052,300.00** | **35,700.00** | **99.68** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,312,300.00 | 2,312,300.00 | - | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,775,700.00 | 8,740,000.00 | 35,700.00 | 99.59 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **80,246,900.00** | **74,455,210.00** | **5,791,690.00** | **92.78** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 67,083,300.00 | 61,794,960.00 | 5,288,340.00 | 92.12 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,163,600.00 | 12,660,250.00 | 503,350.00 | 96.18 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **75,072,200.00** | **70,650,324.00** | **4,421,876.00** | **94.11** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **75,072,200.00** | **70,650,324.00** | **4,421,876.00** | **94.11** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 75,072,200.00 | 70,650,324.00 | 4,421,876.00 | 94.11 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,279,963,500.00** | **1,279,998,500.00** | **-35,000.00** | **100.00** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,277,651,200.00** | **1,277,651,200.00** | **-** | **100.00** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,277,651,200.00 | 1,277,651,200.00 | - | 100.00 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **2,312,300.00** | **2,347,300.00** | **-35,000.00** | **101.51** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,312,300.00 | 2,347,300.00 | -35,000.00 | 101.51 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 72,210,901.00 | | |

## Орон нутгийн төсвийн гүйцэтгэл

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **273,144,300.00** | **267,610,508.00** | **5,533,792.00** | **97.97** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **273,144,300.00** | **267,610,508.00** | **5,533,792.00** | **97.97** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **273,144,300.00** | **267,610,508.00** | **5,533,792.00** | **97.97** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **46,811,700.00** | **46,423,462.00** | **388,238.00** | **99.17** |
| 210101 | Үндсэн цалин | 46,811,700.00 | 44,387,654.00 | 2,424,046.00 | 94.82 |
| 210102 | Нэмэгдэл | - | 2,035,808.00 | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **5,851,400.00** | **3,239,674.00** | **2,611,726.00** | **55.37** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,979,000.00 | 2,788,784.00 | 1,190,216.00 | 70.09 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 468,100.00 | 112,722.50 | 355,377.50 | 24.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 374,500.00 | 90,177.97 | 284,322.03 | 24.08 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 93,600.00 | 22,544.53 | 71,055.47 | 24.09 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 936,200.00 | 225,445.00 | 710,755.00 | 24.08 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **210,481,200.00** | **207,947,372.00** | **2,533,828.00** | **98.80** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,000,000.00 | 8,997,548.00 | 2,452.00 | 99.97 |
| 210302 | Түлш, халаалт | 199,981,200.00 | 197,449,824.00 | 2,531,376.00 | 98.73 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000.00 | 1,500,000.00 | - | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **10,000,000.00** | **10,000,000.00** | **-** | **100.00** |
| 210604 | Урсгал засвар | 10,000,000.00 | 10,000,000.00 | - | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **273,144,300.00** | **267,610,508.00** | **5,533,792.00** | **97.97** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **273,144,300.00** | **267,610,508.00** | **5,533,792.00** | **97.97** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 273,144,300.00 | 267,610,508.00 | 5,533,792.00 | 97.97 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **-** | **100** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **24** | **24** | **-** | **100** |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 24 | 24 | - | 100 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**1.6.1** ***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:*** Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургууль нь бага болон суурь, дунд боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол Шинжлэх Ухааны Яамны харьяа байгууллага юм.

Сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

2022 онд "Багш ажилчдын хариуцлага хамтын ажиллагааг сайжруулж суралцагч бүрийн хөгжлийн үнэлгээнд суурилсан үр дүнг дэмжиж , сайн арга туршлагыг түгээн дэлгэрүүлнэ." гэсэн зорилт тавьж ажиллажээ.

Сургуулийн захирал Түнэл сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 77 арга хэмжээг төлөвлөж, 92.1 хувьтай дүгнэгдсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:*** 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож , "хувьсах зардал"-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:
   - Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.
   - Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор "Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн", "Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр", "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал" баталсан байна.
   - БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
   - БШУС-ын 2022 оны А/170 дүгээр тушаалаар "төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар"-ыг 1 дүгээр, "багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар"-ыг 2 дугаар, "цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ыг 3 дугаар, "тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх заавры г 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
   - БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар "Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар"-ыг баталсан байна.
   - БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
   - БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал "Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай"
   - БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаал " Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам"
   - БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.

***Байгууллагын дотоод хяналтын талаар:*** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу сургуулийн захирлын 2022 оны А/23 дугаар тушаалаар дотоод хяналтын багийг байгуулж, А/30 дугаар тушаалаар ажиллах журмыг шинэчлэн баталсан байна.

Дотоод хяналтын багаас нь 2022 оны 4-р улиралд дотоод хяналтын төлөвлөгөөгөөр 3 бүлгийн 14 ажлыг хэрэгжүүлэхээр батлуулсан болович сургуулийн эрүүл ахуйн, аюулгүй байдалтай холбоотой 1 хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Түүнчлэн 2022 онд сургуулийн захирлын тушаалаар шинээр гарсан дүрэм, журмуудын хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсөв санхүүг зарцуулах, түүнд хяналт тавих, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, шинээр гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий зөвлөл, ажлын хэсгүүдийг томилж ажиллуулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:*** Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа БСШУС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 49,011.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | - | 72,210.9 | 72,210.9 |
| Авлага | - | 9,872.0 | 9,872.0 |
| Бараа материал | 157,879.3 | 179,761.1 | 21,881.8 |
| Үндсэн хөрөнгө | 2,560,442.5 | 2,505,489.2 | -54,953.3 |
| **Нийт хөрөнгө** | **2,718,321.7** | **2,767,333.2** | **49,011.5** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,718,321.7 | 2,767,333.2 | 49,011.5 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө / өмчийн дүн** | **2,718,321.7** | **2,767,333.2** | **49,011.5** |

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, эздийн өмч дансдууд өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 72,210.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Авлага дансны үлдэгдэл 9,872.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 2022 оны 12 дугаар сард цахим дэлгүүрээс худалдан авахаар Саммит компьютер технологи ХХК-тай гэрээ байгуулж, төлбөр шилжүүлсэн боловч тайлант онд нийлүүлэгдээгүй ухаалаг самбарын үнийг авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.
3. Бараа материал дансны үлдэгдэл 21,881.8 мянган төгрөгөөр өсөхөд хүнсний материалын үлдэгдэл өмнөх оноос нэмэгдсэн нь нөлөөлжээ.
4. Үндсэн хөрөнгө данс 54,953.3 мянган төгрөгөөр буурахад тайлант үеийн элэгдлийн зардал голлон нөлөөлсөн байна. Тайлант жилд 82,278.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмж орлогод авснаас 37,741.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд худалдаж авч, 12,759.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар, 31,778.7 мянган төгрөгийн хөрөнгийг системийн дээд байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан байна.
5. Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүн 51,701.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, аудитын явцад 2,690.0 мянган төгрөгийн залруулгыг өмнөх үеийн үр дүнд хийлээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

**Улсын төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:**

Тус байгууллагын 2022 оны төсвийг 1,042,825.9 мянган төгрөгөөр баталсан бөгөөд төсвийн жилийн дундуур төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр төсвийн хуваарьт дараах байдлаар өөрчлөлт оруулсан байна. Үүнд: БШУС-ын 2022 оны 3 дугаар сарын 24-ны А/105 тоот тушаал, 2022 оны 10 дугаар сарын 7-ний өдрийн А/258 дугаар тушаал, 12 дугаар сарын 30-ны өдрийн А/392 тоот тушаалаар тус тус өөрчлөлт оруулснаар анхны баталсан төсвийг 234,825.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлжээ.

Ингэснээр нийт төсвийн зарлагыг 1,279,963.5 мянган төгрөгөөр, үүнээс 1,277,651.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэх, 2,312.3 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан байна.

**Орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:**

Тус байгууллагын 2022 оны төсвийг Түнэл сумын ИТХ-ын хуралдаанаар 352,426.5 мянган төгрөгөөр баталж, төсвийн жилийн дундуур тодотгол хийж 79,282.2 мянган төгрөгөөр бууруулан 273,144.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь жилийн эхэнд орон нутгийн төсөвт батлагдсан төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, шимтгэлийн зардлыг тодотголоор улсын төсвөөс санхүүжүүлэх болсонтой холбоотой.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 1,277,651.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 273,144.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, нийт 1,550,795.5 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлого 2,312.3 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,347.3 мянган төгрөгийн төвлөрүүлж, 101.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын гүйцэтгэл 98.0 хувьтай, төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 5,533.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлсэн.

Улсын төсвөөс санхүүжих зардал 94.4 хувийн гүйцэтгэлтэй, зарцуулагдаагүй үлдэгдэл 72,210.9 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр байршиж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | Улсын төсвөөс санхүүжих | | | | |
| 1 | 80226- Байр ашиглалтын үйлчилгээ | 3,510.3 | 3,325.0 | 185.3 | 94.7 |
| 2 | 80312-Сургалт семинар | 1,755.1 | 1,750.0 | 5.1 | 99.7 |
| 3 | 81605-Эрүүл мэндийг дэмжих | 4,036.8 | 4,036.0 | 0.8 | 100.0 |
| 4 | 81801-Үдийн цай хөтөлбөр | 75,072.2 | 70,650.3 | 4,421.9 | 94.1 |
| 5 | 81806-Дотуур байрны үйлчилгээ | 117,678.9 | 114,865.7 | 2,813.2 | 97.6 |
| 6 | 81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 41,960.0 | 37,741.0 | 4,219.0 | 89.9 |
| 7 | 81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх | 7,898.2 | 7,873.8 | 24.4 | 99.7 |
| 8 | 81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 874,056.6 | 819,686.7 | 54,369.9 | 93.8 |
| 9 | 81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 151,683.1 | 145,546.8 | 6,136.3 | 96.0 |
| 11 | 81848-Сурах бичгийн түрээс | 2,312.3 | 2,312.3 | 0.0 | 100.0 |
| | **Дүн** | **1,279,963.5** | **1,207,787.6** | 72,175.9 | 94.4 |
| | Орон нутгийн төсвөөс | | | | |
| 1 | 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 220,481.2 | 217,947.4 | 2,533.8 | 98.9 |
| 2 | 80112-Нийтлэг үйлчилгээ | 52,663.1 | 49,663.1 | 3,000.0 | 94.3 |
| | **Дүн** | 273,144.3 | 267,610.5 | 5,533.8 | 98.0 |
| | **Нийт дүн** | **1,553,107.8** | **1,475,398.1** | **77,709.7** | **95.0** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн аудитор Ц.Мөнхтуяа гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Б.Мядагмаа хийж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,296,478.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 25,929.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төсвийн байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 30 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 заалтад заасан Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулах заалтаас бусад заалтыг хэрэгжүүлсэн байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй асуудалд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн ба тайлангийн 4.4.1 хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хэмнэлтийн горимыг баримталж, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дагавар нь төрийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг бууруулахгүй байх зарчмыг баримтлан ажилласан ба 2,533.8 мянган төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд 2022 онд нийт 151 мэдээлэл оруулахаас 5 мэдээллийн мэдээлэх хугацаа болоогүй, тайлант хугацаанд мэдээлэх 146 мэдээллээс 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Мэдээллийн агуулга, үнэн зөв байдлыг шалгахад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 362,175.0 мянган төгрөгийн 14 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөрчил таслан зогсоох албан шаардлагыг биелүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Шилэн дансны мэдээлэл хариуцсан ажилтанд хариуцлагын арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэв.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 1 зөвлөмж, 1 албан шаардлага өгснөөс 1 зөвлөмжийг 100 хувь биелүүлж, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил таслан зогсоох албан шаардлагыг хэрэгжүүлээгүй асуудалд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн болно.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | 10,170.0 | - | - | - |
| Зөвлөмж | 1 | 242.0 | 1 | 242.2 | 100.0 |
| **Нийт дүн** | **2** | **10,412.0** | **1** | **242.2** | **50.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар төсвийн жил дамжин хэрэгжиж байгаа сургалтын үйл ажиллагаа, хувьсах зардлын нөхөн хангалтаар авч байгаа тоног төхөөрөмжийг хүлээн авч, орлогод авсан эсэх, сургуулийн үйл ажиллагаанд ашиглахаар худалдан авч байгаа сургуулийн удирдлагын цогц системийн ашиглалт, мөнгөн үлдэгдлийн зарцуулалтад анхаарах шаардлагатай гэж үзлээ.

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор баталсан зардлын зориулалт, арга хэмжээ, нормативын дагуу төсвийг тооцон шинжлэхэд 198,985.9 мянган төгрөгийн санхүүжилтийн илүү тооцоо гарч байна. Энэ нь 2022 онд Засгийн газрын шийдвэрээр багш нарын болон үйлчилгээний ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлсэн, орон нутгийн төсвөөр санхүүжүүлэхээр баталсан үйлчилгээний ажиллагсдын цалин хөлсийг улсын төсвөөс олгосонтой холбоотой боловч төсвийн төлөвлөлтийг сайжруулахад холбогдох байгууллагууд анхаарах шаардлагатайг харуулж байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 444,038.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс нийцлийн аудитаар илэрсэн шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 362,175.0 мянган төгрөгийн 1 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага өгч, 57,746.5 мянган төгрөгийн 4 алдааг залруулсан. Сангийн сайдын 2019 оны 190 дүгээр тушаалаар баталсан эдийн засгийн ангилал зөрүүлсэн 24,117.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар дараах нягтлан бодох бүртгэлийн залруулгыг хийсэн болно. Үүнд:

- Цахим дэлгүүрээс худалдаж авахаар 12 дугаар сард гэрээ байгуулж, төлбөр төлсөн боловч тайлант онд нийлүүлэгдээгүй 9,872.2 мянган төгрөгийн ухаалаг самбарыг орлогод авсныг авлагаар залруулан бүртгэсэн.
- Түрээсийн сурах бичгийг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байсныг 1,918.9 мянган төгрөгийн залруулга хийж, эргэлтийн хөрөнгөнд бүртгэсэн.
- Өмнөх онд зарцуулсан 2,690.0 мянган төгрөгийн барилгын материал дансны үлдэгдэлд бүртгэлтэй байсныг өмнөх оны үр дүнд залруулга хийж данснаас хассан.
- Үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоолны зардал 43,265.5 мянган төгрөгийг 2022 оны 10 дугаар сараас эхлэн тус тусад нь бүртгээгүй, нийлүүлж хоолны зардлаар бүртгэснийг тус тусын зардалд залруулж бичилт хийсэн.

### 5.1 Албан шаардлага

Аудитаар илэрсэн 2 зөрчилтэй асуудалд дараах албан шаардлагыг хүргүүлсэн болно.

Сангийн сайдын 2019 оны 190 дүгээр тушаалаар баталсан эдийн засгийн ангилал зөрчиж 24,117.0 мянган төгрөгийн дараах гүйлгээг хийсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;" заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул зөрчил таслан зогсоох хугацаатай албан шаардлагыг хүргүүллээ. Үүнд:

1. Цалингийн зардлаас ажиллагсдад түлээний үнийн хөнгөлөлт 19,800.0 мянган төгрөг олгосон.
2. Орзон хоршоо руу 2022 оны 2 сарын 28-ны өдөр үдийн хоолны мөнгө шилжүүлэхдээ дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас гаргаж, эдийн засгийн ангилал зөрүүлсэн.

Нийцлийн аудитын хүрээнд хийсэн Шилэн дансны ахуулийн хэрэгжилтийг шалгахад тайлант онд байршуулбал зохих 146 мэдээллээс 10 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан, өмнөх оны аудитаар өгсөн зөрчил таслан зогсоох албан шаардлагыг биелүүлээгүй байх тул байгууллагын шилэн дансны мэдээлэл хариуцсан ажилтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Биетээр байхгүй хөрөнгийг орлогод авсан. | 1 | 9,872.0 | | | | | 1 | 9,872.0 | | | | |
| Түрээсийн сурах бичгийг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн. | 1 | 1,918.9 | | | | | 1 | 1,918.9 | | | | |
| Өмнөх онд зарцуулсан материалыг данснаас хасаагүй үлдэгдлээр бүртгэсэн. | 1 | 2,690.0 | | | | | 1 | 2,690.0 | | | | |
| Үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг тус тусад нь бүртгээгүй, нийлүүлж хоолны зардлаар бүртгэсэн. | 1 | 43,265.5 | | | | | 1 | 43,265.5 | | | | |
| | **4** | **57,746.4** | | | | | **4** | **57,746.4** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад |

| | | | | | | | | | | | шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Сангийн сайдын 2019 оны 190 дүгээр тушаалаар баталсан эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн. | 2 | 24,117.0 | | | 2 | 24,117.0 | | | | | | |
| Дүн | **2** | **24,117.0** | | | **2** | **24,117.0** | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаагүй | 1 | 362,175.0 | | | 1 | 362,175.0 | | |
| Дүн | **1** | **362,175.0** | | | **1** | **362,175.0** | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | **1** | **362,175.0** | | | **1** | **362,175.0** | | |

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 27 өдөр № 31/A22604139/ХОА-2023/174 /ША-СТА-ТШЗ Мөрөн сум

*Сахилгын хариуцлага тооцуулах тухай*

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн дагуу байршуулах 146 мэдээллээс 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 17 орлого, зарлагын 362,175,000 (Гурван зуун жаран хоёр сая нэг зуун далан таван мянга)-н төгрөгийн 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.
2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д *"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"*, 6 дугаар зүйлийн 6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.5-д "*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;*" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 *"Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ."*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т *"Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ."* гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй, зөрчил гаргасан нягтлан бодогч Г.Жадамбад хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт[1] ирүүлэхийг Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Нямдэлгэрт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР: Б.ДАВААНЯМ

[1] Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302 тоот Утас: 70384043

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 02 сарын 07 өдөр № 39/A2260439/ХОА-2023/174/НА-СТА-ТЦЗ Мөрөн сум

*Зөрчил арилгуулах тухай*

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлаас ажиллагсдад түлээний хөнгөлөлт 19,800,000 (арван есөн сая найман зуун мянга)-н төгрөг олгосон, Орзон хоршоо руу үдийн хоолны мөнгө 4,317,000 (дөрвөн сая гурван зуун арван долоон мянга)-н төгрөгийг шилжүүлэхдээ дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас шилжүүлж нийт 24,117,000 (хорин дөрвөн сая нэг зуун арван долоон мянга)-н төгрөгийн гүйлгээг эдийн засгийн ангилал зөрчиж гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” заалтыг хэрэгжүүлээгүй, Сангийн сайдын 2019 оны 190 дүгээр тушаалаар баталсан төсвийн эдийн засгийн ангилал зөрсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно*” гэж заасныг тус тус үндэслэн

**ШААРДАХ нь:**

1. Төсвийг батлагдсан төсвийн хүрээнд, эдийн засгийн ангиллын дагуу гүйлгээг хийж байх, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт[1] ирүүлэх;
2. Цаашид гарсан зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, ажиллахыг Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Нямдэлгэр, нягтлан бодогч Г.Жадамба нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР: Б.ДАВААНЯМ

[1] Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043